



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 5.6, 7.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тээврийн прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 46,900,000.00 (дөчин зургаан сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Дөргөний усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын өрөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Тээврийн прокурорын газрын өрөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ц.Арвинбуудай, Эрчим хүчний төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр гүйцэтгэгч М.Батгэрэл, “Дөргөний усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000880

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн
45.5 дугаар тогтоолын хавсралт

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС “ДӨРГӨНИЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИЦЛАТАЙ КОМПАНИД БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖКҮҮЛЭХ АВТОМАШИН**

| Д/Д | Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон ОН | Нийт гүйлт (км) | Балансын үнэ (төгрөг) | Хууримтлагдсан элээдээл (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг) | Цаашид ашиглах (жил) |
|-----------------|--|---|--------------------|---|---|-------------------------------------|-------------------------|
| 1 | Ниссан Кашкей, 06-91 УБҮ, SJNFBNJ10Z2373313, Суудлын автомашин | 2011/2011 | 65655 | 46,900,000.00 | 46,900,000.00 | 5,000,000.00 | 2 |
| НИЙТ ДҮН | | | | 46,900,000.00 | 46,900,000.00 | 5,000,000.00 | 2 |
| | | | | (дөчин зургаан сая есөн зүүн мянган) | (дөчин зургаан сая есөн зүүн мянган) | (таван сая) | - |